

Монгол, солонгос хэлний ‘улаан’ хэмээх өнгө заасан
нэрийн танин мэдэхүйн онцлог

Ким Ынь Жон¹
Монгол Улс, Улаанбаатар,
Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль,
Гадаад хэлний салбар

Submitted: September 25, 2025 | **Accepted:** November 15, 2025

Хураангуй: Энэ өгүүлэлд өнгө нь харах мэдрэхүйгээр дамжин хүний тархинд тусдаг боловч угсаа гарал өөр үндэстний хувьд хэл-бие махбод-соёлын ялгаанаас хамааран өөр өөрөөр илэрдэг болохыг монгол, солонгос хэлний “улаан” өнгөөр жишээ болгон судлан үзэв. Монгол, солонгос хэлний “улаан” өнгийг танин мэдэхүйн түвшинд харьцуулан үзэхэд зүйрлэл болон төлөөллийн аргаар үүсэх арга зам нь адилхан бөгөөд дэлхий нийтийн нийтлэг хандлагаар “улаан” өнгө нь цус, хувьсгал, тэмцэл зэргийг нэрлэдэг шинжээрээ адил юм. Улаан өнгөөр нэрлэсэн үгийн бусад ялгаатай утга нь хоёр ард түмний шашин шүтлэг, ёс заншил, танин мэдэхүйн арга барилын ялгаанаас үүсэлтэй болох нь харагдаж байна.

Түлхүүр үг: танин мэдэхүй, өнгөний бэлгэдэл, улаан өнгө, соёлын код, метафор, метоним

A Cognitive Study of the color "red" in Mongolian and Korean

Kim Eun Jeong
Department of Foreign Languages,
International University of Ulaanbaatar,
Ulaanbaatar, Mongolia

¹ © Ким Ынь Жон, 2025
Email: jakaprayer@gmail.com

Abstract: *This study investigates the cognitive linguistic characteristics of the color term red, expressed as ulaan in Mongolian and bulgda in Korean. Drawing on the Mongolian–Korean bilingual dictionary compiled by Dankook University, the research examines the metaphorical and metonymic extensions of red-related expressions in both languages. In this study, first, we confirmed cognitive universality in that "red" holds a high status as a basic color term in both languages, and is strongly associated with primal natural phenomena and life elements such as "blood," "fire," and "sun." Second, emotional associations showed that in both cultures, the color 'red' tended to be associated with intense and polarized emotions such as 'passion', 'love', 'anger', and 'danger'.*

This study verifies that while the color 'red' in both Mongolian and Korean shares a universal human cognitive framework, it possesses unique distinctions in lexical usage and cultural interpretation. These distinctions arise due to the influence of different natural environments and Shamanistic/Confucian cultural backgrounds prevalent in the respective societies. These findings make a significant contribution to understanding the impact of language and culture on color perception and cognition.

Keywords: *basic color words, color symbolism, red color, metaphor, metonymy, cognitive*

1. Удиртгал

Хүн өнгийг мэдэрч танин мэдсэний дараа сэтгэхүйдээ хийсвэрлэнэ. Энэхүү хийсвэрлэн сэтгэхийн үндэс нь таван мэдрэхүйн туршлага юм. Өөрөөр хэлбэл, хүн харах, сонсох, амтлах, хүртэх, үнэрлэх таван мэдрэхүйгээрээ хүрээлэн буй орчноо танин мэддэг. Эдгээрээс харах мэдрэхүй нь аливаа зүйлийг шууд тусган тархинд мэдээлэл дамжуулдаг. Тиймээс бид угсаа гарал өөр хүмүүсийн өнгийг ойлгох, нэрлэх ялгаа нь зөвхөн харааны мэдрэмжээс гадна тархиар дамжин өнгөрдөг мэдрэлийн замуудаас үүдэлтэй.

Им Жи Рён нь танин мэдэхүйн хэл шинжлэл нь бидний ертөнцийг хэрхэн хүлээн авч, хэрхэн ойлгож байгаад үндэслэн "хэл", "бие махбод ба оюун ухаан", "соёл"-ын хоорондын харилцан хамаарлыг тодруулахыг эрмэлздэг гэжээ. Тиймээс өнгөтэй холбоотой үгсийн утгын тэлэлтийн судалгаа нь танин мэдэхүйн хэл шинжлэлийн утга зүйн аргуудаар дамжин хэлний хоорондын харилцан хамааралд гол анхаарлаа хандуулах ёстой (2010: 9).

Нүүдэлчин монголчууд болон суурин амьдралтай солонгосчуудын амьдралын хэв маяг хүрээлэн буй орчин, соёлын нөхцөл байдлаас шалтгаалан 'улаан' өнгийг нэрлэх танин мэдэхүйн зүйрлэл, төлөөллийн илэрхийлэлд ялгаа гарах магадлалтай. Гэсэн хэдий ч суурин болон нүүдэлчин соёлын өнө эртний түүхтэй орны Монгол, Солонгос Улс нь "ижил төстэй боловч ялгаатай", "зэргэлдээ мөртөө төстэй" гэсэн соёлын кодуудыг илэрхийлдэг.

Хүний амьдралын туршлага нь тухайн улс орны түүх, соёл, амьдралын хэв маяг, сэтгэлгээ, онцлогтой үндсэндээ холбоотой байдаг бөгөөд эдгээр нь хэлэнд тусгалаа олж, хэлээр илэрхийлэгддэг.

2. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны зорилго орчин цагийн монгол хэлний “улаан /ulaan/” болон солонгос хэлний “불다 /bulgda/” хэмээх өнгө заасан үгийн үүслийг танин мэдэхүйн болон соёлын үүднээс харьцуулан судлах юм. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд дараах зорилтыг тавив. Үүнд:

- Метафор, метонимийн давтамж ба төрлүүдийн шинжилгээ: Тодорхой ойлголтуудыг (жишээлбэл, сэтгэл хөдлөл, цаг хугацаа, хийсвэр ойлголт) илэрхийлэхийн тулд монгол хэлний метафор ба метонимийн давтамж ба үндсэн төрлүүдийг тодорхойлох.
- Соёлын суурийн шинжилгээ: Монгол метафор, метоним нь нүүдэлчний соёл, бөө мөргөл болон танин мэдэхүйн бие махбодын туршлагад соёлын өвөрмөц элементүүдэд хэрхэн тусдаг болохыг шинжилж, эдгээрийг солонгос хэлний ижил төстэй илэрхийлэлтэй харьцуулах.
- Танин мэдэхүйн механизмын тайлбар шинжилгээ: Метафор, метонимийн хэрэглээ нь танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс монгол хэл, монгол хүний сэтгэлгээ, ертөнцийг үзэх үзлийг хэрхэн тусгаж, бүтэцжүүлж тайлбарлах.

Энэхүү судалгаа нь хам цагийн судалгаанд хамаарах бөгөөд харьцуулсан хэл шинжлэлийн задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга болон тоон өгөгдлийн шинжилгээний арга, танин мэдэхүйн шинжилгээний аргыг ашиглав. “Монгол-солонгос толь бичиг”-ээс авсан 56 метафор, 53 метонимийн өгөгдөлд үндэслэсэн юм. Монгол хэлний “улаан” гэдэг үгийг солонгос хэлний “улаан” гэдэг үгтэй харьцуулахын тулд зохиолч Ч.Лодойдамбын нийт 167,935 үг (давтамжийг оруулахгүй бол 19,869 үг)²-ээс бүрдсэн “Тунгалаг Тамир” роман болон Ю Вонсү (유원수)-ийн орчуулсан солонгос хэл дээрх “Тунгалаг Тамир” романаас “улаан” хэмээх өнгө заасан нэр орсон өгүүлбэрүүдийг жишээ болгон ашиглав.

3. Өнгөний талаарх ойлголт, судалгаа

Бид өнгийг оюун ухаандаа хийсвэрлэн бэлгэдлийн утгаар бодох нь өнгөөр төлөөлүүлэх сэтгэхүй юм. Хүн нүднээ өртөн тусах өнгөний дотроос сонголт хийж, тэрхүү танин мэдсэн өнгөний мэдлэгээрээ тухайн зүйлийг төлөөлүүлдэг. Хүний харааны танин мэдэх чадварын үндэс нь өнгийг танин мэдэж (cognition) болон мэдэрч (perception) ялгах чадвар юм. Хүний нүдээр хүртэж мэдрэх зүйлд хэлбэр дүрс, шинж байдал, хөдөлгөөнөөс гадна өнгө багтана. Өнгийг аливаа юмнаас цацарч ойх гэрлийн долгионыг нүднээ хүртээх сэрэл (МХТТ: 1582) гэж тайлбарлажээ.

² Т.Пүрэвсүрэн (2015), “Монгол хэлний цахим хөмрөг байгуулах асуудалд”. диссертаци, 39-р тал.

Антропологич Берлин, Кей (Brent Berlin, Paul Kay, 1969)³ нар хүмүүс өнгөний ангилалд “үндсэн өнгө (basic color term)”-ийн нэрийг тусгал (focal color) өнгө болгон ашигладаг болохыг нотолсон (Им Жи Рён, 2018: 489). Доорх зурагт үзүүлсэнчлэн, үндсэн арван нэгэн өнгө заасан нэр дараах үгсээс бүрдэж байна.

Хүснэгт 1. “Өнгө заасан нэрийн шатлал”

I	II	III	IV	V
				grey
		yellow	blue	orange
	< ⁴	<	<	
white	red	green		purple
				pink

Хүснэгт 1-ийн II хэсэгт цагаан, хар, улаан гэсэн гурван өнгө ордог бол V-т I-ээс V хэсгийн бүх өнгө багтана гэж үздэг байна. Энэхүү судалгааг прототипын⁵ ангилалд эмпирик ололт гэж үздэг. Ж.Баянсан нь аливаа өнгө хүн, ертөнц хоёрын хоорондох дотоод үйлдэлд хамаатай зүйл болохоос биш, өнгө дангаараа ертөнцөд байдаггүй гэж хэлсэн. Өнгийг таньсны дараа хүн оюун ухаандаа оюуншуулан хийсвэрлэдэг (2022: 44).

Өнгийг аливаа хэлээр илэрхийлэх, мэдрэх нь урт хугацааны ой санамжид хадгалагддаг бөгөөд мөн өнгийг харахдаа өмнөх мэдээлэлтэй холбож ойлгодог (Хун Жон Инь, 2012: 50). Өнгөний мэдрэмж⁶ гэдэг нь захын мэдрэлийн системийг мэдрэхүйн эсүүд өдөөх үед үүсдэг мэдрэхүйн туршлага юм. С.Дулам нь “өнгө, түүний ойлголтын талаар туршилт хийхэд, энэ нь хүмүүсийн үнэт зүйл, сэтгэхүй соёлоос хамааран ихээхэн ялгаатай байдгийг баталжээ. Мөн өнгө заасан нэр нь дүрслэл болон давхар утгыг агуулдаг гэжээ (2011: 309).

3.1. Монгол хэлний “улаан” хэмээх өнгөний тухай ойлголт

Барууны орнуудад улаан өнгө нь өөр гарвал утгатай байж болох ч амьдралын эх сурвалж болох цусны өнгөтэй нягт холбоотой нь нийтлэг зүйл юм. Энэхүү “цусны өнгө”-ийн бэлгэдэл нь улс орнуудын төрийн далбаанд ч тусгалаа олсон байдаг. Христийн шашинд улаан дарс нь Христийн цусыг бэлгэддэг бөгөөд дайны ба цэргийн улаан өнгөтэй туг нь “цусаараа хамгаалсан” гэсэн утга

³ 1969 онд “Үндсэн өнгийн нэр томъёо: Тэдний ертөнц ба хувьсал” номыг бүтээжээ.

⁴ ‘<’ тэмдэглэгээ нь “нөхцөлт түгээмэл шинж”-ийг илэрхийлэх бөгөөд энэ нь өнгө заасан үгсийн хувьд зүүн талд байгаа үг нь баруун талынхаа үгийг шатлан захирах ёсоор захирч байгааг заана.

⁵ эх дүрийн онол (prototype theory)

⁶ Өнгөний мэдрэмж (color perception) гэдэг нь гэрэл биетэд ойж, нүдээр дамжсаны дараа тархинд өнгө хэмээн танин мэдэгдэх хүртэлх үйл явцыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, харааны мэдээллийг боловсруулсны үр дүнд өнгийг мэдрэх үзэгдлийг илэрхийлдэг.

илэрхийлдэг. Ромд туг мандуулах нь цус урсган дайтах болно гэсэн довтолгооны дохио байв.

Орчин цагийн солонгос хэлний “улаан” -тай тохирох монгол хэлний үг нь “улаан”, монгол бичгээр /ulaγan/ юм. Улаан бол баяр баясгалангийн өнгө бөгөөд ялалт, зочломтгой байдлын бэлгэ тэмдэг юм. Ардын урлагт энэ нь эрхэмсэг, гоо үзэсгэлэнг илэрхийлэх ба монгол охид цэвэр ариун, залуу насны бэлгэ тэмдэг болгон толгойдоо улаан тууз зүүдэг (Пак Хван Ён, 2012:34).

Улаан өнгийн бэлгэдлийн утга нь улс орон бүрд харилцан адилгүй байдаг. Эрт дээр үеэс гал болон дөлийг бэлгэддэг нь нь түгээмэл зүйл. Монголчуудын бөө мөргөлийн зан үйлд улаан утас нь амьдралын шугам, цусны урсгал, улаан цусыг бэлгэддэг (С.Дулам, 2000: 200). Нэг талаар баяр баясгалан, гоо үзэсгэлэн, хайр дурлал, сэтгэл хангалуун амьдралыг бэлгэддэг бол нөгөө талаар өшөө авалт, уур хилэн, дайн тулааныг илэрхийлдэг нь эерэг ба сөрөг үнэлэмж зэрэгцэн байдгийг харуулж байна. Б.Ринчен (1984) нь Монголын бөөгийн шашинд амьд амьтан бүр эцгээсээ цагаан үр (яс), эхээсээ улаан үр (мах) авдаг гээд тэрбээр эдгээр яс, мах нь амьдралын хоёр хэлбэрийг бүрдүүлдэг гэж тайлбарладаг (Пак Хван Ён, 2002: 65). Мөн “Нүүдэлчдийн амьдралд хамгийн олон тохиолддог таван өнгө бол ногоон, цагаан, шар, хөх, улаан бөгөөд эдгээрийн бэлгэдэл нь ногоон нь нугын ногоон зүлэг, цагаан нь цагаан идээ, сүү, шар нь лам хувраг, хөх нь тэнгэр, улаан нь баяр баясгалангийн бэлгэдэл юм (2002: 59) гэжээ.

Монголчууд үеэс үед өнгөөр бэлгэдэж ирсэн нь улсын төрийн далбааны өнгөнөөс тодорхой харагддаг. Монгол Улсын төрийн далбаанд улаан, хөх, шар өнгө байх ба улаан өнгө нь хөгжил дэвшлийг, хөх өнгө нь тэнгэрийг, соёмбо нь шар өнгөтэй бөгөөд нар болон галыг бэлгэдэж, доторх галын дөл нь өнгөрсөн, одоо, ирээдүйг төлөөлүүлж мөнхөд хөгжиж байх болтугай гэсэн бэлгэдэлт утгыг агуулдаг. Галын дөлний доорх “нар, сар” нь арга билгийг илэрхийлдэг билээ. Өнгө заасан нэр нь монголчуудын хувьд маш чухал байр суурь эзэлдэг. Жишээлбэл, “Цагаан морь бол тэнгэрийн гурван бурхны морь” гэсэн хэлц үг байдаг. Монголчуудын бэлгэдлийн нэг хэлбэр нь хоол хүнсийг өнгөөр бэлгэддэг явдал юм. Таван тансаг идээ нь хар – архи, цагаан – сүү болон цагаан идээ, шар – сайн чанарын шар тос, улаан – мах, хөх – жимс гэж илэрхийлдэг. Үүнээс үзэхэд, үндэстэн бүрд өнгийг ойлгох байдал, соёлын бэлгэдэл нь өөр байдаг. (Г.Гантуяа, 2018: 18).

3.2. Солонгос хэлний “улаан” хэмээх өнгөний тухай ойлголт

Солонгос хэлний “улаан” хэмээх үг нь “улаан + да” гэсэн нийлмэл бүтэцтэй бөгөөд “улаан” буюу гал (火) гэсэн үгийн гаралтай нягт холбоотой. (Чой Чан Рёл, 1986: 233). “Гэрэл” (光) гэдэг үг нь гэрэл (光) болон өнгө (色) хоёрыг зэрэг илэрхийлдэгтэй адил “гал” (火 hwa) хэмээх үг нь мэдрэхүйн төлөвийг илэрхийлдэг “гэрэл (밝다/balgda)”, “улаан (붉다/bulgda)” гэсэн мөн хоёр утгад хуваагдсан бололтой байдаг. Энэ нь гэрэл болон өнгийн мэдрэмжийг адилтгаж байсан эртний ухамсрын илэрхийлэл юм.

Улаан өнгийг галтай холбоотойг хятад ханз үсгээс мэдэж болно, тухайлбал, улаан (赤) тэмдэгт нь том (大) болон гал (火) гэсэн тэмдэгтийн нийлбэр болно.

Монголтой адил Солонгост ч бас бэлгэдэх (тотемизмын) ёс заншил бий. Солонгос хэл өнгөтэй холбоотой үг, ялангуяа өнгө заасан тэмдэг нэрээр баялаг хэл юм. 불다 /bulgda/ улаан гэх үгийн үндэс нь 불 /bul/ (火) гал гэсэн утгатай ханзны үг юм. Солонгос хэлэнд 적 /chog/ (赤) улаан өнгө нь таван махбодын нэг болох 화 /hwa/ (火) галын өнгө бөгөөд өмнөд зүгийг төлөөлдөг. Нарны илч нь түгэн дэлгэрэх бүхний эх үндэс болохын сацуу амьдралыг тэтгэн дэлгэрүүлэгч, ивээн хамгаалах хүчийг бэлгэддэг өнгө юм. Мөн өвөрмөц зан заншил шившлэгийн утгаар хамгийн их хэрэглэгддэг өнгө бөгөөд голчлон чөтгөрүүдийг зайлуулах зорилгоор ашигладаг байжээ. Жишээлбэл, нар буцах өдөр улаан буурцгийн зутан идвэл улаан буурцгийн улаан өнгө нь сахиус болдог гэж үздэг байсан. Мөн хүү төрөхөд муу муухайгаас хамгаалахын тулд үүднийхээ гадна улаан чинжүү тавих юм уу, сахиусыг заавал улаан өнгөөр бичдэг гэх зэрэг ардын ёс заншилд илэрдэг. Мөн муу ёрын сүнснийг зайлуулахад улаан өнгийг голчлон ашигладаг гэж үзэх нь уугуул хүмүүсийн итгэл үнэмшилд томоохон байр эзэлдэг. Жишээлбэл, өвлийн туйл дээр улаан буурцгийн будаа идэх нь буурцгийн улаан өнгө муу ёрын сүнснийг зайлуулдаг гэж үздэгтэй холбоотой. Шар буурцгийн соус хийхэд улаан чинжүү хөвдөг, хүүгээ төрүүлэхдээ улаан чинжүүг хаалганы гадна өлгөж, бохирдлоос хамгаалдаг, сахиусыг улаан өнгөөр бичдэг, улаан цэцгийн шүүсээр хумсаа будаж эрүүл энх, амар амгалангийн төлөө залбирдаг зэрэг ёсон солонгос ардын аман зохиолын олон жишээнээс харж болно. Мөн улаан өнгийг хүүхдийн зуун өдрийн найр, анхны төрсөн өдөр, хурим, билгийн тооллын 5-р сарын 5-нд болдог уламжлалт баяр 단오 /dano/, өвлийн туйл буюу хамгийн богино шөнө урт өдрийг тэмдэглэдэг 등지 /dongji/ гэхчлэн баярын өдрөөр хийж иддэг хоол хүнс, үндэсний хуримын хувцас 활옷 /hwalot/ зэрэгт хэрэглэнэ. Бэр хадамдаа ирэхэд хүргэний аяганд цагаан наалдамхай будаа, сүйт бүсгүйн аяганд улаан буурцаг дүүргэж Хонгбо⁷ ороосон байдаг. Энэхүү заншил нь наалдамхай будаа шиг тэсвэр тэвчээр, энхрийллээр аз жаргалтай амьдрах, гай зовлонгоос зайлсхийх, олон хүүтэй болохыг бэлгэддэг.

“Улаан” өнгийн талаарх ойлголт нь бэлгэдлийг илэрхийлэхийн сацуу хэлний сэтгэлгээнд зүйрлэл, төлөөлөл гэсэн танин мэдэхүйн үндсэн хоёр хэв маягтай салшгүй холбоотой байна.

4. Монгол, солонгос хэлний “улаан хэмээх өнгө заасан үгийн танин мэдэхүйн онцлог

Монгол хэлний үгийн санд олон утгат үг (polysemy) үүсгэх аргын нэг нь төлөөлөл (synecdoche) юм. Төлөөлөл бол бүхэл зүйлийг хэсгээр нь нэрлэх, эс бөгөөс бүхлээр нь хэсгийг нэрлэх хүний хэл, сэтгэхүйн холбооны маш чухал үйлдлийн илрэл билээ.

Монгол хүний хэлний сэтгэхүйн үйлдлийг илэрхийлсэн монгол хэлний

⁷ Хонгбо (hongbo, 紅襪): Солонгосын уламжлалт соёлд ерөөл бэлгэдлийг агуулсан зүйлийг ороож хамгаалдаг улаан өнгийн даавуун боодол юм. (Чой Чан Рёл, 2002: 115)

төлөөлөн нэрлэж байгаа арга ухааныг дараах байдлаар ангилав.

1. Хүнийг эрхтний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй
2. Амьтныг эрхтний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй
3. Ургамлыг хүний болон амьтны эрхтний нэрээр төлөөлөн нэрлэхүй
4. Юмсыг хэсгийн нэрээр нь төлөөлөн нэрлэхүй (Д.Бадамдорж, 2018) гэх

мэт.

Монгол хэлэнд хүний эрхтний нэрээр бүхэл хүнийг төлөөлүүлэх нь түгээмэл бөгөөд “дөрвөн өлөн ам, хүн ам” гэх мэт жишээнээс харж болох ба ‘гар’ гэдэг үгээр баруун гар (сайн нөхөр), их гар (бүтэлгүй хүн, дээрэмчин), хүнд гар (дэггүй хүн), урт гартай (хулгайч), гар хөл болох (хань хамсаатан нь болох) гэх мэтээр төлөөлүүлдэг. Дээрх онолд тулгуурлан дараах монгол, солонгос хэлний “улаан” өнгийн танин мэдэхүйн онцлогийг танин мэдэхүйн үүднээс авч үзэж болно.

4.1. Монгол, солонгос хэлний “улаан” хэмээх өнгө заасан үгийн толь бичгийн утга

Монгол, солонгос хэлний өнгөний талаарх сэтгэлгээг ойлгохын тулд хоёр хэлний толь бичгийн тайлбарыг харвал дараах байдалтай байна.

1) Монгол хэлний тайлбар толь бичигт

Хүснэгт 2.

Өнгө	Тодорхойлолт
Улаан	1. Гал ба цус мэтийн өнгө 2. Хувьсгалын утга чанар бүхий 3. Биеэр, халхлах, жийрэглэх юмгүй 4. Юмыг хэтрүүлэн хийгч, цагаандаа гарсан, балмад 5. Нялх балчир 6. Шунахай, ховдог

Монгол хэлэнд улаан хэмээх үгийн хэсэг нь бүхлээ төлөөлдөг.”Улаан арьстан” гэдэг нь европынхон Америк тивийг эзлэхийн өмнө амьдарч байсан уугуул оршин суугчдыг хэлдэг. Улаан өндөгний баярыг дахин амилалтын баяр гэж мөн хэлдэг бөгөөд Христийн шашин загалмайд цовдлогдож хорвоогоос хальсан Есүс гурван өдрийн дараа дахин амилсан явдлыг тэмдэглэдэг өдөр юм. Үүнд хэсэг нь бүхлийг төлөөлж байна.Улаан загалмайн нийгэмлэг нь дайны цагт өвчтэй, шархтай цэргүүдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, тайван цагт гэнэтийн аюулд нэрвэгдсэн хүнд туслах үүрэгтэй сайн дурын байгууллага, цагаан өнгөн дээр улаан загалмай тэмдэгт бүхий эмблемтэй. Энэ нь цагаан дэвсгэр дээр улаан өнгөөр зурсан Грекийн загалмайн тэмдэг бөгөөд одоо тусламжийн ажил гүйцэтгэдэг байгууллагыг илэрхийлэх болсон байна.

2) Солонгос хэлний тайлбар толь бичигт

Хүснэгт 3.

Өнгө		Тодорхойлолт
붉다 (улаан)	bulgda (붉다)	1. Цус эсвэл сайн боловсорсон чинжүүний өнгө 2. Коммунист үзэлтэн болох 3. Цус эсвэл сайн боловсорсон чинжүүний өнгө мэт болох
	ppalgahda (빨강다)	Цус эсвэл сайн болгосон чинжүү мэт гэрэлтсэн хүрэн улаан өнгө
	bulgeunsaeg (붉은색)	Хүний уруул эсвэл цусны өнгө мэт өтгөн тод өнгө
	ppalgansaeg (빨간색)	Цус эсвэл сайн болгосон чинжүүтэй адил гэрэлтсэн өтгөн улаан өнгө

Солонгос хэлний улаан өнгөний тухай толь бичгийн тайлбараас монгол хэлнээс ялгаатай болохыг нь харж байна. Солонгос хэлний тайлбар тольд туссан улаан өнгө заасан 4 үгийн тус бүрийн бүтэц үүнийг баталж байна.

4.2. Монгол, солонгос хэлний “улаан” хэмээх өнгө заасан үгийн зүйрлэлийн онцлог

Энэ хэсэгт монгол, солонгос хэлний “улаан” өнгийн ойлголт танин мэдэхүйн зүйрлэх аргаар хэрхэн илэрдэг болохыг харьцуулан авч үзье. Өнгөний талаарх танин мэдэхүйн суурь ойлголт адил боловч соёлын хүрээ нь хоёр хэлэнд ялгааг бий болгож байна.

1) Амьдрал, үхэл, бие махбодтой холбоотой зүйрлэл

Хүснэгт 4.

Монгол хэл	Солонгос хэл	Зүйрлэлийн төстэй байдал
Улаан гол	숨통, 목숨 амь нас, амин судас	Улаан өнгө нь амьдралын эх булаг болох “цус” эсвэл “амин судас”-ыг бэлгэддэг.
Улаан голоо тасартал	숨통이 끊길 때까지, 죽을 때까지 амь тасартал, үхтлээ	“Улаан зүйл” буюу амь тасрах нь амьдралын төгсгөлийг илэрхийлдэг.
Улаан хоолой	생명, 삶, 살림살이 амьдрал, амь нас, амьдрах үйл	Биеийн эрхтэн болох хоолойг амьдралын зам, амьд явах үйлтэй зүйрлэдэг.
Улаан нэлий /улаан нялай	피가 흥건한, 피투성이 цусанд будагдсан, цус дүүрэн	“Улаан өнгө”-өөр цустай, шархтай байдлыг дүрслэн хэлдэг.
Улаан суга	겨드랑이 부분으로 (급소)	“Улаан” мах ил гарсан эмзэг

	суга орчимд (эмзэг газар)	хэсгийг онцолдог.
Улаан гар	직접 하다, 맨손으로 하다 гараараа хийх, нүцгэн гараар хийх	“Улаан, нүцгэн гар”-аар шууд, ямар ч тусламжгүй хийхийг бэлгэддэг.

Нэмэн тайлбарлавал, ‘улаан нэлий, улаан нярай’ гэдэг нь солонгос хэлний “цуст” гэсэн үгтэй төстэй утгатай. Энэ хэллэгээр “шинэ төрсөн хүүхэд”-ийг зүйрлэн илэрхийлдэг. ‘Улаан’ нь шинэ төрсөн хүүхдийн арьсны өнгийг, харин нярай, нялх нь залуу, бага гэсэн утгатай. Тиймээс ‘улаан нэлий, улаан нярай’ гэдэг нь ‘шинэ төрсөн хүүхэд’-ийг бэлгэддэг бол монгол хэлэнд нялх хүүхдийг мөн “улаан цурав” буюу арьс хөрсгүй гэсэн утгаар илэрхийлдэг. ‘Улаан гол’ нь “амьдрал бол улаан зам, гарц” эсвэл “амь амьдрал” гэсэн зүйрлэсэн ойлголтыг илэрхийлдэг.

2) Улс төр, үзэл суртал, нийгмийн тухай зүйрлэл

Хүснэгт 5.

Монгол хэл	Солонгос хэл	Зүйрлэл төстэй байдал
Улаан арьстан	홍색 인종 (아메리카 원주민) улаан арьстнууд	Арьсны өнгө бус, Европчуудын ноёрхлын үед гарсан нэршил.
Улаан арми, Улаан цэрэг	적군, 붉은 군대 улаан арми, хувьсгалч цэрэг	“Улаан өнгө” нь коммунизм ба хувьсгалын үзэл.
Улаан загалмайн нийгэмлэг	적십자사 Улаан загалмайн нийгэмлэг	Улаан загалмайн дүрс нь хүмүүнлэгийн байгууллагын бэлгэдэл.
Улаан булан, Улаан гэр	주민 센터, 문화원 иргэдийн төв, соёлын төв	Хувьсгалын болон социалист нийгмийн үеийн хамтын соёлын орон зайг илэрхийлдэг.
Улаан данс	좋은 것들만 가입한 장부, 적색 목록(멸종 위기) онцгой, устгах аюултай зүйлийн жагсаалт	“Улаан өнгө”-ийг онцгой, аюултай эсвэл ховор зүйлийг тэмдэглэхэд хэрэглэдэг.
Хэт улаан цацраг	혁명의 뜻을 나타내는 말 хувьсгалын утга	“Хэт улаан туяа”-г хувьсгалын нөлөөтэй зүйрлэдэг.

Улаан өнгө нь социализм буюу коммунизмын дайчин шинж чанарыг илэрхийлдэг. Үүнийг тухайлбал, ЗХУ болон Хятад зэрэг социалист орнуудын далбааны өнгөнөөс харж болно. Солонгос хэлний “빨강 (улаан) +이(и)” гэсэн нийлэмж бүхий “빨강이 /bbalgeng-i/” хэмээх хэлц үгийг коммунист хүнийг доромжлон хэлэхэд хэрэглэдэг. Үүнээс “улаан социалист”, “улаан коммунист” гэх хэллэг үүсчээ. Улаан загалмай нь “улаан бол золиос” гэсэн цогц ойлголтыг харуулсан цагаан дэвсгэр дээрх улаан дүрс юм. Тус тэмдгийг бүх эмнэлгийн болон хүмүүнлэгийн ажилтнууд зүүх ёстой. Мөн дайн болж буй бүс нутаг дахь тээврийн хэрэгсэл, барилга байгууламж дээр тэмдэглэх ёстой бөгөөд уг тэмдэгтэй ямар ч машин, барилга руу дайтагч талын цэрэг довтлох ёсгүй юм. Түүнчлэн, солонгос хэлэнд загалмай нь Христийн шашны бэлгэдэл юм. Солонгос хэлний “загалмайг үүрэх” зэрэг хэлц нь Есүс загалмайг мөрөн дээрээ

үүрч ууланд гарсан явдлаас үндэслэсэн гэж үздэг. Иймээс “зовлон, хохирол нь загалмай” гэж ойлгогдон, улаан өнгийн бэлгэдлээр илэрхийлдэг. Улаан арми/улаан цэрэг, улаан булан/улаан гэр зэрэг нь үзэл суртлын зүйрлэл дээр үндэслэсэн. Тэгэхлээр улаан өнгө нь түүхэн нөхцөл байдал (коммунизм ба социалист хөдөлгөөнүүд)-ын хүрээнд үзэл суртал, нийгмийн зохион байгуулалтыг ойлгох хүрээ болж өгдөг.

3) Сэтгэл хөдлөл, зан чанар байдлыг онцлох зүйрлэл

Хүснэгт 6.

Монгол хэл	Солонгос хэл	Зүйрлэл төстэй байдал
Улаан зээрд болох	몸이 빨강게 될 정도로 많이 취하다, 만취하다 улайтал согтох/ бүрэн согтох	“Улаан” өнгөөр архинд мансууран улайх байдлыг зүйрлэнэ .
Улаан галзуу	거친 성격을 가진, 과격한 ширүүн зан ааштай, догшин	“Улаан дөл” мэт халуун, баригдашгүй зан чанарыг зүйрлэнэ.
Улаан нүцгэн	과격한, 난폭한 догшин/хэрцгий	“Нүцгэн бие” шиг ичгүүргүй, илт догшин занг зүйрлэнэ.
Улаан худалч Улаан яргачин Улаан луйварчин Улаан дээрэмчин	늘 거짓말하는 사람, 학살자 등 (악행 강조) худалч, хулгайч зэрэг муу хүн	“Улаан өнгө”-өөр муу үйл, цус, ичгүүргүй байдлыг дээд зэргээр зүйрлэн илэрхийлнэ.
Улаан нялзрай Улаан цурав	아주 어린, 갓난아이 нялх хүүхэд/нярай	Хүүхдийн улаан нялзрай арьс нь “шинэ төрсөн”, “цэвэр ариун” байдлын зүйрлэл болно.
Улаан нүдтэй	욕심이 많은, 탐욕스러운 шунахай/хомхой	Цус хурсан улаан нүдээр “шунахай, хүсэлд шатсан” байдлыг зүйрлэнэ.
Мөнгө цагаан, нүд улаан	돈을 위해 무엇이든 할 수 있는 (탐욕 속담) мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй хүн/ “мөнгөнд нүд сохордог”	“Цагаан” (мөнгө) ба “улаан” (нүд) -ийг эсрэгцүүлж, хүний шуналыг илэрхийлнэ.

4) Байршлын болон нүүр тулах утга илэрхийлсэн зүйрлэл

Хүснэгт 7.

Монгол хэл	Солонгос хэл	Зүйрлэл төстэй байдал
Улаан гол	관역의 정중앙 байны яг голд нь/гол оноо	Улаанаар тэмдэглэсэн нум болон бууны байг “оновчтой” гэсэн утгаар зүйрлэнэ.
Улаан зам	바로 앞에, 바로 눈앞에 яг өмнө/яг нүдний өмнө	“Улаан зам” нь саадгүй, шулуун гэсэн утгыг илэрхийлнэ.

Улаан тулгарах	바로 부딪치다, 맞부딪치다 шууд мөргөлдөх/нүүр тулах	“Улаан тулгарах” нь нуугдаж далдлагдахгүй шууд таарахыг зүйрлэнэ.
Улаан нүүрээрээ учрах	직접 만나다, 얼굴을 맞대다 нүүр тулан уулзах/шууд уулзах	“Улаан нүүрээрээ учрах” нь нүүрээ нуухгүй, илэн далангүй уулзахыг зүйрлэнэ.
Улаан цайм	대놓고 ил тод/нууж хаалгүй/шууд	“Улаан цайм” нь нууж хаагаагүй, ил тод байдлыг зүйрлэнэ.

“Улаан нүүрээр учрах” (шууд харааны холбоо барих) гэсэн хэллэг нь бие махбодын туршлагын зүйрлэл дээр үндэслэсэн байна. “Улаан/нүцгэн царай буюу улаан зам” нь шууд байдлын танин мэдэхүйн хүрээ буюу ямар нэг будаггүй, нуугдаагүй, яг урд нь, ил гэсэн утга илтгэнэ.

5) Эрүүл мэнд, өвчинтэй холбоотой зүйрлэл

Хүснэгт 8.

Монгол хэл	Солонгос хэл	Зүйрлэл төстэй байдал
Улаан суулга/Улаан ёлхдос	이질 цусан суулга	Цустай гүйлгэх өвчний шинжийг зүйрлэнэ.
Улаан бурхан	홍역 улаанбурхан	Бүтэн биеэрх улаан тууралтыг зүйрлэнэ.
Улаан эсэргэнэ	성홍열 халууны улаан	Арьсан дээр улаан тууралт гарахыг зүйрлэнэ.

‘Улаан бурхан’ хэмээх үгийг жишээ татвал, агаар дуслын замаар дамждаг вирусээр үүсгэгддэг цочмог халдварт өвчин юм. “Улаан бурхан өвчнөөр өвдөөгүй хүн үхсэн хойноо ч өвддөг” гэсэн солонгос ардын зүйр үг бий. Энэ зүйр үг нь хүн бүр амьдралынхаа туршид дор хаяж нэг удаа энэ өвчнийг тусдаг гэсэн үг юм.

4.3. Монгол, солонгос хэлний “улаан” хэмээх өнгө заасан үгийн төлөөллийн онцлог

1) Өнгө, гадаад төрхийг илэрхийлсэн төлөөлөл

Хүснэгт 9.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
Улаан буга	붉은사슴 (학명): Cervus elaphus	Амьтны улаан өнгийн үс
Улаан гоёо (ургамал)	쇠양 (학명): Cynmorium songaricum	Улаан туяатай ургамлын онцлог)

Улаан бургас (ургамал)	물벼들 (학명): Усны бургас	Иш, мөчир нь улаан өнгөтэй ургамал
Улаан хальст (амьтан)	두꺼비 (붉은 꺾질) Мэлхий (улаан арьстай)	Амьтны улаан арьс/хальс
Улаан хошуут (шувуу)	붉은부리까마귀 Улаан хошуут хэрээ	Улаан хошуутай амьтан
Улаан хөл (шувуу)	작은 새의 한 종류 (죽엽작) Жүхөпжак (жигжиг шувуу)	Бараан улаан хөлтэй амьтан
Улаан хүзүүт (шувуу)	수화관 Сухуагуан	Улаан хүзүүтэй амьтан)
Улаан цоохондой (амьтан)	적리(붉은 표범처럼 생긴 고양이과 동물) (улаан ирвэс шиг муурын овгийн амьтан)	Улаан өнгийн толботой амьтан)
Улаан лууван (ургамал)	갯무 (학명): Далайн лууван	Улаан өнгийн лууван/манжин)
Улаан манжин (ургамал)	빨간순무, 근대 Улаан манжин, манжин навчит	Улаан үндэс эсвэл навчтай ургамал

Дээрх үгс нь улаан өнгийг ашиглан амьтан, ургамлын нийтлэг дүр төрхийг төлөөлөн илтгэдэг. Улаан буга, улаан нүдэн, улаан тарлан, улаан халтар, улаан хонгор, улаан хүрэн, улаан хээр, улаан цоохор, улаан шарга, хундан улаан, улаан ногоон, улаан болжмор, улаан бор азарга, улаан гарди, улаан дэлбэ, улаан сарт тогшуурга, улаан толгойт, улаан туруу, улаан хошуут хэрээ, улаан хөл, улаан хүзүүт, улаан цоохондой, улаан бор, улаан зээрд (амьтан), улаан гоёо, улаан долоогоно, улаан лооль, улаан лууван, улаан манжин, улаан бударгана, улаан бургас, улаан бутаргана, улаан буудай, улаан зандан, улаан толгой, улаан тулам, улаан түлээ, улаан уд, улаан харгана, улаан хоног, улаан цахирмаа цэцэг, улаан салаат цахирмаа цэцэг (ургамлууд) нь монгол хэлний улаан өнгөтэй холбогдолтой үгсийн онцлогийг илтгэн харуулдаг. Монгол адууны өнгө зүсэм 300 гаруй төрөл байдаг ба тэдгээрийг үндсэн өнгө болон холилдсон өнгөнд нь тулгуурлан нэрлэдэг өнгө ялгах өндөр соёлын уламжлал өнөөг хүртэл хадгалагдан ирсэн байна. Мөн уул усны нэрэнд 5 өнгө (цагаан, улаан, шар, хар, хөх)-ийг өргөн хэрэглэдэг нь монголчуудын өнгөний талаарх онцгой мэдрэмж, гоо зүйн хандлагыг илтгэнэ.

Монголчуудын танин мэдэхүйн онцлогийг харуулах улаавар, улаандуу, улаагчин гэх зэрэг өнгийг зөвхөн өөрсдөдөө л ойлгогдох эд зүйлийн нэрээр нэрлэсэн. (Г.Гэрэлмаа, 2017: 61). Эдгээр амьтан, ургамлын нэр улаан өнгөтэй туйлын адилхан биш боловч илүү давамгай өнгөөр нь бусад өнгөтэй амьтнаас ялган төлөөлүүлж нэрлэсэн нь элбэг байдаг.

2) Үүрэг, зорилго илэрхийлсэн төлөөлөл

“Улаан” (улаан) нь тодорхой үүргээр дамжуулан бүхэл бүтэн объектыг илэрхийлж бэлгэддэг.

Хүснэгт 10.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
Улаан бэх	전사 (가루로 만든 사각형 잉크) Жинш буюу улаан бэх (Циннабар нунтагтай дөрвөлжин тамганы бэх)	Материал/хэрэгсэл (бичих, засах зориулалттай)
Улаан гэрэл	적색 신호등 Улаан гэрлэн дохио	Тээврийн дохио (зогсох үйлдлийг илэрхийлнэ)
Улаан цоохор болгох	오류나 문체 등을 붉은색 펜으로 수정하다 Алдааг улаан балаар засах	Үйлдэл/нөхцөл (засах үйлдэл)
Улаан дарс	적포도주, 레드와인 Улаан дарс	Ундаа

Дээр дурдсан улаан өнгө заасан үгсийн дундаас “улаан гэрэл” нь замын уулзвар болон явган хүний гарц дээр зогсохыг заасан дохионы улаан гэрэл гэсэн шууд утгатай бөгөөд битүү утгаараа аюул, болгоомжлолыг илтгэх уур амьсгалыг илэрхийлнэ. Мөн хоолны дуршил хэвийн бус болж нэмэгдэх эсвэл буурах эрүүл мэндийн асуудлын анхааруулах шинж тэмдгийг мөн улаан гэрэл гэдэг үгээр илэрхийлнэ. Солонгос хэлээр “Экспортын фронтод улаан гэрэл асна” гэдэг нь бүх зүйл хэвийн явж байгаа үед ч юм уу, ямар нэг зүйлд асуудал үүсэх үед урагш ахихад саад гарах, бэрхшээл үүсэхийг анхааруулдаг гэж ойлгож болно. Энэ нь гэрлэн дохионы тухай тайлбартай төстэй. Улаан гэрлэн дохионы улаан өнгө нь “зогсоох” гэсэн үүргийг төлөөлнө. Улаан нь мөн “залруулах” гэсэн утгатай улаан өнгийн үзгийн үүргийг ч гүйцэтгэнэ.

3) Төлөв, үзэгдлийг илэрхийлсэн төлөөлөл

“Улаан” нь байгалийн тодорхой үзэгдэл, түүний төлөв байдлыг илэрхийлдэг.

Хүснэгт 11.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
Улаан салхи	흄먼지를 일으키는 강한 바람 Шороо тоос босгодог хүчтэй салхи	Байгалийн үзэгдэл (улаан шороотой салхи)
Улаан шороо	거센 바람에 의해 일어나는 흄먼지 Хүчтэй салхинаас үүсэх шороо тоос	Бодис (улаан өнгөтэй шороо тоос)
Улаан өндөг (шувуу)	주홍색 알을 낳는 새의 한 종류 Улаан өндөг гаргадаг шувууны нэг төрөл	Шувууны өндөг
Улаан хагсмал боорцог	전 밀가루에 설탕과 찹레 열매를 넣어 튀긴 과자 Бууцайтай гурилд сахар, бэрсүүт жүрж хийж шарсан амттан	Хоолны орц (орц нь улаан туяатай)
Улаан идээ	빨간 음식 Улаан хоол	Хатаасан мах (өвлийн хүнсний нөөц)

Монголд “улаан идээ” (улаан хоол) гэдэг нь голчлон төрөл бүрийн малын махан хүнсийг хэлдэг бөгөөд Монголын хатуу ширүүн уур амьсгал, ялангуяа урт, хүйтэн өвлийг даван туулах шим тэжээлийн эх үүсвэр юм. Улаан идээ, түүгээр хийсэн хоол хүнс хэрэглэх нь амьд үлдэхтэй шууд холбоотой. Намар амьтдыг нядалж, махыг байгалийн мөчлөгийн дагуу хадгалах нь нүүдэлчдийн улирлын чанартай болон байгаль орчинд дасан зохицох чадвартай холбоотой байна. “Улаан идээ” гэх үг нь өвлийн хоол хүнсээ бэлтгэхийн тулд амьтдыг хамгийн тарган үед нь нядлан арьсыг нь хуулахад харагдах махны өнгийг төлөөлүүлсэн нэр юм. Эрт дээр үеэс малын мах нүүдэлчдийн хувьд үнэ цэнтэй хөрөнгө байсаар ирсэн бөгөөд өөх тос ихтэй улаан мах нь элбэг дэлбэг байдал, эд баялгийг бэлгэддэг. Мөн улаан өнгө нь байгалийн үзэгдэл буюу эд зүйлсийн төлөв байдлыг илэрхийлдэг ба “улаан салхи”, “улаан шороо” нь ногоо ургаагүй, шороо ихтэй газрыг төлөөлүүлсэн хэллэг юм.

4) Газар, орон илэрхийлсэн төлөөлөл

“Улаан” гэдэг нь газрын нэрийн төлөөлөл бөгөөд нэг хэсгээр бүхлийг илэрхийлэх утгатай.

Хүснэгт 12.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
Улаанбаатар	Улаанбаатар (Монголын нийслэл)	Газар нутгийн нэр (Улаан баатар гэсэн утгатай)

“Улаанбаатар” хотын нэр шиг өнгө, үзэл суртлыг хослуулсан, тодорхой улс төр, түүхэн байгууллагыг бэлгэддэг төлөөллийн аргаар үүссэн газрын нэр дэлхий даяар цөөнгүй бий. Ялангуяа “улаан” нь коммунизм болон социалист хувьсгалын бэлгэдлийн өнгө байсан тул доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн эдгээр төлөөлөл нь хуучин Зөвлөлт Холбоот Улс болон түүний харьяанд байсан орнуудын газрын нэрд өргөн хэрэглэгддэг. Красноярск хот, Красные площадь-Улаан талбай зэрэг нь төлөөлөл юм. Өөрөөр хэлбэл, “улаан” гэдэг нь энгийн өнгө биш, харин тодорхой эрин үе, үзэл суртлыг бэлгэдсэн хийсвэр ойлголтыг тодорхой газрын нэрээр илэрхийлсэн төлөөлөл юм.

Хүснэгт 13.

Уг бичлэг	Бүрдэл хэсгүүд ба үгийн утга	Улс төр / түүхийн хүрээдэх утга)
Улан-Удэ (Орос/Буриад)	Улан + Удэ	ОХУ-ын хот. Монгол хэлний ‘улаан’-тай ижил гаралтай бөгөөд ЗХУ-ын үеийн хувьсгалын утгыг илэрхийлдэг.
Красноярск	Красный + Яр	Сибирийн гол хот. Эрт дээр үе байгалийн улаан шорооноос үүссэн боловч, ЗХУ-ын үеэс хувьсгалын улаан өнгөтэй давхцаж ашиглагдсан.

5) Шашин шүтлэгийг илэрхийлсэн төлөөлөл

Хүснэгт 14.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
улаан сахиус	붉은 수호신 Улаан хамгаалагч	Бэлгэ тэмдэг (муу сүнсийг хөөж, ариусгах хүчтэй)
Улаан өндөгний баяр	부활절 Дахин амилсны баяр	Өндөг (шинэ амьдрал ба дахин төрлийг бэлгэддэг.)

Улаан бол “улааны шашин” эсвэл “улаан малгайтан” гэх мэт буддизмын улаан малгайтын урсгалыг (нингма) төлөөлдөг шашны нэрийн бэлгэдэлт утга юм. Монголын шашны орчинд улаан сахиус онцгой ач холбогдолтой юм. Монголчуудын дунд “улаан сахиус” хэмээн алдаршсан Жамсран бурхны нэрийг төвөдөөс орчуулбал “эгч дүүс” гэсэн утгатай. Цэрэг дайны хүчээр түрэмгийлэн хорлогчдыг номхруулагч, догшин сахиус бол Улаан Жамсран юм. Энэ сахиусыг шүтэн, үйл хэргээ даатгаж, тангараг өргөх ёс Автай сан хааны үеэс эхлэн анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар болон дараа, дараагийн Богдуудад уламжлагдсан байдаг.⁸ “Ирсэн сум, далайсан сэлмээс зайлуулж чадах улаан сахиусын⁹ хувилгаан хүн гэж цэргүүд ярилцдаг байв” (МТТ: I-44) “날아오는 총알, 치켜든 군도를 비켜 가게 할 수 있는 붉은 수호신의 화신이시다!”라고 이야기했다” (СТТ: I -48) “Улаан сахиус” нь “муу ёрыг зайлуулж, аз авчирдаг сахиусын шинж чанарыг” илэрхийлсэн төлөөлөл юм. Бөө мөргөл болон Буддын шашинд улаан өнгө нь муу ёрын сүнсийг зайлуулж, ариусгах хүчтэй гэж үздэг тул хувь хүмүүсийн биедээ авч явдаг сахиуст улаан өнгийн утас, улаан даавуу зэргийг ихэвчлэн ашигладаг. Энэ нь хамгаалагч бурхан буюу сахиусаар дамжуулан хүчирхэг хамгаалалтын хийсвэр ойлголтыг илэрхийлдэг шашны төлөөлөл юм.¹⁰ Солонгост сахиус 부적 /bujjeog/ ба 부작 /bujag/ гэж хоёр янз байдаг. 부적 /bujjeog/ нь муу муухайг хөөн зайлуулдаг бөгөөд шар өнгийн цаасан дээр улаанаар бичдэг. Харин 부작 /bujag/ нь чулуу, мод, төмөр, шанага, хулс мод, амьтан эсвэл хүний эд юмсаар муу сүнсийг хөөж, буян хишгийг дуудаж хүслийг нь биелүүлж өгдөг сахиус юм. Муугаас зайлсхийж, сайн сайхныг

⁸ <https://meall-video-blog.translate.goog/>

⁹ Төвөдийн буддын шашны догшин сахиус Жамсран (Begtse)-ы тухай Данкүк их сургуулийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн гаргасан 『Монгол-солонгос хэлний их толь бичиг』 몽한대사전 (蒙韓大辭典), Данкүк их сургуулийн хэвлэлийн газар, 2023, 2095-р талд "их улаан сахиус" буюу "дайны тэнгэр" хэмээн тэмдэглэсэн байдаг.

¹⁰ Ламын өмсгөл (улаан дээл 紅衣): Монголын Буддын шашинд лам нарын уламжлалт улаан өнгийн өмсгөл нь тухайн шашны бүлэг, номлол болон тэдний шүтлэг бишрэлийн үйл хэргийг бүхэлд нь төлөөлөх метаноним илэрхийлэл байдаг.

хүсэмжлэх нь (제액초복, 除厄招福)¹¹ хүний хамгийн анхдагч бөгөөд халуун хүсэл юм. Сахиус бол амьдралыг тэтгэх хүмүүний анхдагч хүслийн бэлгэдэл ажээ. Мөн ‘Улаан өндгийн баяр’ (Easter) гэдэг үгийн улаан нь Есүс Христийн улаан цусыг бэлгэддэг бөгөөд Христийн шашинд аврал, амьдрал гэсэн утгатай. Өндөг нь шинэ амьдрал, амилалтыг бэлгэддэг. Улаан өндөг нь зүгээр л будсан өндөг биш, харин Христийн шашны хамгийн чухал үзэл суртлын үйл явдал болох Есүсийн үхэл, түүгээр дамжуулан мөнх амийн амилалтыг төлөөллөөр илэрхийлдэг.

б) Сэтгэл хөдлөл илэрхийлсэн төлөөлөл:

Хүснэгт 15.

Монгол хэл	Солонгос хэл	Төлөөлөл объект
улаан хөөс	붉은 거품 улаан хөөс	Ам ба хамраас гарах цустай шүлс, хөөсийг санагдуулах бөгөөд энэ нь үхэл эсвэл туйлын зовлонгийн шинж тэмдэг болно.
царай нь улаан болох	흰 얼굴이 빨개지다 цагаан нүүр улайх	‘Царай улайх’ гэх хэллэгийн нэгэн адил хүний гадаад биеийн шинж тэмдэг болон дотоод сэтгэл зүйн байдлыг илэрхийлсэн хэл зүйн хувирал бүхий төлөөлөл юм.
улаан хоолой	생명, 삶, 살림살이 амьдрал, амь нас, амьдрах үйл	Биеийн эрхтэн болох хоолойг амьдралын зам, амьд явах үйлтэй зүйрлэдэг.

“Улаан хөөс” нь цус эсвэл үхэл ба шархны төлөв байдлын шууд үр дүн (тэмдэг) тул шалтгаан, үр дагавар болон бүхэл, хэсгийн хоорондын хамаарал нь тодорхой. Солонгос хэлэнд ч мөн адил ийм уурссан байдал буюу уур бухимдлаа гадагш илэрхийлж буйг амнаасаа хөөс цахруулан гэхийг “입에 (게)거품을 물다” (ibe georumeul mulda) гэж илэрхийлдэг, үгчилбэл “хавч хөөс зуух” гэсэн үг бөгөөд монгол хэлэнд хүний ам, солонгос хэлэнд хавчаар дүрсэлсэн нь сурвалж хүрээ нь ялгаатай байна. “Царай нь улаан болох” нь шалтгаан, үр дагавар, төлөв байдлыг тэмдгээр дамжуулан илэрхийлдэг төлөөлөл юм. Хүний сэтгэл зүйн өөрчлөлт нь бие махбодод ч өөрчлөлт авчирдаг. Тэдгээрийн нэг бол айж түгших үед царай улайх явдал юм. Энэ тохиолдол нь сэтгэл хөдлөл ба биед илрэх өөрчлөлт хоёрын хооронд бий болж буй шалтгаан болон үр дагаврын харилцан хамаарал юм. Дээрхтэй адил утга илтгэх солонгос хэлний “얼굴이 홍당무가 되다” (eolguri hongdangmuga dweda) царай нь улаан лууван болох, “상기(上氣)되다” (sang-i dweda/хөөрч улайх) зэрэг үгсийг дурдаж болно. Энэ үед сэтгэл хөдлөл нь шууд бус, далд байдлаар илэрч байдаг. Нүүдлийн соёлд мал амьтныг (морь, хонь, ямаа гэх мэт) нядлах, махыг нь эвдэх нь өдөр тутмын амьдралынх нь чухал хэсэг байдаг. Нядлах явцад дотор эрхтэн, биеийн хэсгүүдийг нарийн ажиглах боломж их бөгөөд, ялангуяа улаан хоолой болон залгиур нь салст бүрхэвч, судаснаас шалтгаалан илүү улаан өнгөтэй байдаг. Тиймээс “улаан

¹¹ “제액초복 (除厄招福)” гэдэг нь “азгүйдлийг арилгах, сайн сайхныг урих” гэсэн утгатай дөрвөн тэмдэгт хэлц үг юм. Өөрөөр хэлбэл, муу энергийг арилгах, аз хийморийг урих гэсэн утгатай бөгөөд гол төлөв сахиус буюу бөөгийн зан үйлтэй холбоотой байдаг.

хоолой” гэдэг нь хийсвэр ойлголтоос илүүтэй нүдээр шууд харж үзсэн туршлагад үндэслэсэн байх хандлагатай. Харин солонгос хэлэнд улаан хоолойг “목 /mog/” буюу хоолой, эсвэл ханз үгээр “식도 /sigdo/” (хоолны зам) гэх мэтээр үүрэг, байрлалд нь үндэслэн нэрлэдэг. Ингэж монгол, солонгос хэлэнд ялгаатай нэрлэлт үүссэн нь танин мэдэх шатны ялгаанаас үүссэн болох нь харагдана.

5. Дүгнэлт

Монгол, солонгос хэлний “улаан” өнгөөр илрэх утгыг танин мэдэхүйн хэл шинжлэлийн аргаар судлан үзэхэд дараах нийтлэг болон ялгаатай тал илэрч байна.

1. Монгол, солонгос хэлний танин мэдэхүйн сэтгэлгээ дэлхий нийтээр улаан өнгийг “цус” болон “гал”-тай зүйрлэх сэтгэлгээтэй адил байгаа нь хүн төрөлхтний эрт үеийн сэтгэлгээнээс үүсэлтэй. “Гал”-ыг улаан хэмээн ойлгох нь дорно дахины ард түмэн таван махбодыг өнгөөр илэрхийлдэгтэй шууд холбогдоно.
2. Монгол, солонгос хэлэнд улаан өнгө нь цус, үхэл, коммунизм, хүсэл тэмүүлэл, хайр, тахал, ичгүүр, уур хилэн зэргийг илэрхийлдэг талаараа адил байна.
3. Солонгос хэлэнд улаан өнгө нь голчлон сэтгэл хөдлөл, төлөв байдлыг илэрхийлэх зорилгоор зүйрлэл хэлбэрээр ашиглагддаг бол монгол хэлэнд объект, шинж чанарыг илэрхийлдэг.
4. Монгол хэлний улаан өнгөтэй холбоотой нэрлэлт солонгос хэлнийхээс илүү олон. Шалтгаан нь монголчуудын амьд биед суурилсан танин мэдэхүй нь илүү хөгжсөнтэй холбоотой. Улаан идээ, улаан цус, улаан хоолой гэх мэт нэрлэлт нь мал ахуйтай ихэвчлэн харьцсаны дүнд амьтны биеийн онцлогийг мэдсэний үндсэн дээр нь үүссэн бол солонгос хэлэнд ийм нэрлэлт байдаггүй ба гол төлөв үүргээр нь нэрлэдэг байна.
5. Мөн монгол хэлэнд “улаан” хэмээх өнгөтэй холбоотой нэрлэлт зарим тохиолдолд орос хэлний нөлөөгөөр орж ирсэн байж болно, тухайлбал, “улаан талбай”, “улаан хувьсгалч” гэх мэт. Өмнөд Солонгост ийм зүйрлэл илрэхгүй байна.
6. Монгол хэлэнд аливаа нэг цаг үеийн урсгал, бүлгийг өнгөөр түүний дотор “улаан”-аар нэрлэсэн нь өвөрмөц. Улаан арми, улааны урсгал, улааны суртал гэх мэт. Харин солонгос хэлэнд Христийн шашны улаан өнгөөр дахин төрөхийг бэлгэдэж “улаан өндөгний баяр” гэж тэмдэглэдэг.

Ном зүй

- Бадамдорж, Д.** (2018). *Монгол хэлний утга зүйн судалгаа*, Улаанбаатар. [Badamdorj, D. *Mongol khelnii utga züin sudalгаа* [Semantics of Mongolian]. Ulaanbaatar, 2018]
- Баянсан, Ж.** (2022). *Танихуйн хэл шинжлэл хэлний соёл судлал-Монгол хэл судлал XIV боть*. Улаанбаатар. [Bayansan, J. *Tanikhuin khel shinjlel*

- khelnii soyol sudlal-Mongol khel sudlal* [Cognitive linguistics, cultural linguistics]. Ulaanbaatar, 2022]
- Гантуяа, Г.** (2018). *Солонгос, монгол хэлний өнгө заасан үгсийн харьцуулсан судалгаа*-Соёлын бэлгэдлийн утга илэрхийлсэн үгсийн жишээгээр-Канвон Их Сургууль. [Gantuya, G. *Solongos, mongol khelnii öngö zaasan ügsiin haritsuulsan sudalгаа* [Comparative Study of Color Terms in Korean and Mongolian]. Ulaanbaatar, 2018]
- Гэрэлмаа, Г.** (2017). Монгол нэр томъёог танин мэдэхүйн хэл шинжлэлийн үүднээс судлах нь (шувууны нэрийн жишээн дээр). *Хэл зохиол судлал. Боть Х (42)*, Улаанбаатар. [Gerelmaa, G. Mongol ner tomiyoog tanin medekhiin khel shinjlelin үүдnees sudlakh ni [Studying Mongolian Terminology from a Cognitive Linguistics Perspective]. Linguistics and Literary studies Т.10, Ulaanbaatar, 2017]
- Дулам, С.** (2011). *Монгол бэлгэдэл зүй*-Өнгийн бэлгэдэл зүй, Чиг зүгийн бэлгэдэл зүй, Улаанбаатар. [Dulam, S. *Mongol belgedel züi-Öngiin belgedel züi, Chig zügiin belgedel züi* [Mongolian Symbolism-Symbolism of Colors, Symbolism of Numbers]. Ulaanbaatar, 2011]
- Дулам, С.** (2000). *Монгол бэлгэдэл зүй*-Дэд дэвтэр, Улаанбаатар. [Dulam, S. *Mongol belgedel züi* [Mongolian Symbolism]. Ulaanbaatar, 2011]
- Им Жи Рён,** (2010, 2018). 임지룡. *환유 표현의 의미 특성, 인문논총. 메토ним (шилжил утгын) илэрхийллийн утгын онцлог*, Хүмүүнлэгийн судлалын тэмдэглэл [Im Ji Ryong. Hwanyu pyohyeonui uimi teugseong [Semantic Characteristics of Metonymic Expressions]. Journal of Humanities. 2010, 2018]
- Монгол-солонгос хэлний их толь бичиг,** (2023). 몽한대사전(蒙韓大辭典), Dankook их сургуулийн хэвлэлийн газар [Monghandaesajeon [Mongolian-Korean Grand Dictionary]. Dankook University, 2023]
- Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь.** (2008). Улаанбаатар. [Mongol khelnii delgerengüi tailbar toli [Comprehensive Explanatory dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar, 2008]
- Пак Хван Ён,** (2002). 박환영. 몽골 샤머니즘 의례에 나타나는 색채 상징에 관한 연구. *한국 샤머니즘 연구*, 5. Монголын бөө мөргөл дэх өнгөний бэлгэдэлд хийсэн судалгаа”, *Солонгос бөө мөргөл судлал*. 5. [Bak Hwan Yeong. Monggol syameonijeum uiryee-e natananeun saekchae sangjing-e gwanhan yeongu. [A Study of Color Symbolism in Mongolian Shamanism]. *Korean Journal of Shamanism*, Vol. 5, 2002]
- Пак Хван Ён,** (2012). 박환영 (2012). *몽골 문화와 상징*. 서울: 민속원. *Монгол соёл ба бэлгэдэл*. Сөүл: Минсуквон. [Bak Hwan Yeong. *Monggol minhwawa sangjing*. [Mongolian Culture and Symbolism]. Seoul: Minsogwon. 2012]
- Хун Жон Инь,** (2012). 홍정인. *색채 인지 체계에 관한 연구-언어적 표상 특성을 중심으로*, 이화여자대학교, 박사논문. *Өнгөний танин мэдэхүйн тогтолцооны судалгаа: хэлний төлөөллийн онцлогийг төв болгосон нь*, Ихва эмэгтэйчүүдийн их сургууль, диссертаци. [Hong Jeong In. Saekchae Inji chyegyee gwanhan yeongu. [Study on the Color Cognitive System:

Focused on the Characteristic of Linguistic Representation], Ewha Womans University. 2012]

Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний товч тайлбар толь*, Улаанбаатар. [Tsevel, Ya. *Mongol khelnii tovch tailbar toli* [Concise Explanatory dictionary of the Mongolian language]. Ulaanbaatar, 1966]

Чой Чан Рёл, (2002). *최종렬. 우리말 語源研究*, 一志社, 일지사 *Солонгос хэлний/үгийн гарал судлал*, Илжиса хэвлэлийн газар. [Choe Chong Nyol, Urimal eowon yeongu [A Study of the Etymology of the Korean Language], Pjisa Publishing Company. 2002]

Ю Вонсү, (2007). *유원수, 밝은 타미르강 1, 2, 민음사* “Тунгалаг Тамир”, роман 1, 2-р дэвтэр, Минымса хэвлэлийн газар. [Yu Won Su, *Malgyen Tamiri Gang* [Tungalag Tamir]. Minumsa Publishing Group, 2007]

Berlin, B., And Kay, P. (1969). *Basic Color Terms: Their University and Evolution*. Berkeley: University of California Press.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>